



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2024 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Гэмт хэргээс урьдчилан
сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн
бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус II хурлаас ТОГТООХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журмын дагуу салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга (Ч.Бат-Оргил)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 сарын 14-ний өдрийн 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ч.БАТ-ОРГИЛ

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

1.Дарга	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
2.Гишүүн	Дүүргийн Засаг дарга
3. Гишүүн	Дүүргийн менежер
4. Гишүүн	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч
5. Гишүүн	Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга
6. Гишүүн	Дүүргийн Цагдаагийн газрын дарга
7. Гишүүн	Дүүргийн Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын хэлтсийн дарга
8 Гишүүн	Б.Сайнхүү /Төлөөлөгч/
9 Гишүүн	Д.Энхтүвшин /Төлөөлөгч/
10 Гишүүн	Б.Хүрэлтулга /Төлөөлөгч/
11 Гишүүн	Б.Батцэрэн /Төлөөлөгч/
12 Гишүүн	С.Ариунтуяа /Төлөөлөгч/
13 Гишүүн	С.Сайнбаяр /Төлөөлөгч/
14 Гишүүн	А.Сүххишиг /Төлөөлөгч/
15 Гишүүн	А.Одбаяр /Төлөөлөгч/

16 Гишүүн	Д.Ганбадрах /Төлөөлөгч/
17 Гишүүн	Н.Наранцацрал /Төлөөлөгч/
18 Гишүүн	П.Мөнх-Эрдэнэ /Төлөөлөгч/
19 Гишүүн	Д.Тэлмэн /Төлөөлөгч/
20 Гишүүн	Б.Амартүвшин /Төлөөлөгч/
21 Гишүүн	Ж.Хишигбаяр /Төлөөлөгч/
22 Гишүүн	Н.Мэндбаяр /Төлөөлөгч/
23. Гишүүн	Э.Насан-Очир /Төлөөлөгч/
24. Гишүүн	Б.Байгалмаа /Төлөөлөгч/
25 Гишүүн	Б.Буманжаргал /Төлөөлөгч/
Нарийн бичгийн дарга	Зөвлөлийн Ажлын албаны дарга

Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 16 дугаар сарын 21-ны өдрийн
07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дүүргийн нутаг дэвсгэрт тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар удирдуулсан дүүргийн салбар зөвлөл /цаашид “салбар зөвлөл” гэх/ зохицуулна.
- 1.2. Салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон ажиллана.
- 1.3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд салбар зөвлөлийн нийт гишүүдийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Хуралдаанаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх, дүүргийн нутаг дэвсгэрийн төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага, олон нийтийн оролцоотойгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг хангах хүрээнд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хариуцсан нутаг дэвсгэртээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг уялдуулан зохицуулна.
- 1.4. Салбар зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд хурлын шийдвэр нь тогтоол, зөвлөмж, мэдэгдэл хэлбэртэй байна. Салбар зөвлөлийн хуралдааныг тэмдэглэл хөтөлж баталгаажуулах бөгөөд түүнд салбар Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Салбар Зөвлөлийн хурлын тогтоол, зөвлөмж, мэдэгдлийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн хэрэгжүүлэх арга хэмжээг авч явц, үр дүнгийн талаар тогтоосон хугацаанд хариу мэдэгдэн дэмжлэг үзүүлнэ.

Хоёр. Салбар зөвлөлийн эрх, үүрэг

- 2.1. Хариуцсан нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах;
- 2.2. Гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцлийг судалсны үндсэн дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, тэргүүлэх чиглэл, түүнийг хэрэгжүүлэх үндсэн арга замыг тодорхойлох;
- 2.3. Дүүргийн нутаг дэвсгэрийн төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага, олон нийтийн оролцоотойгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг хангах хүрээнд иргэд, төрийн бус байгууллагын санал санаачлагыг дэмжин тэднийг энэ ажилд өргөнөөр татан

- оролцуулах, дэмжлэг үзүүлэх;
- 2.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Шүүх, Прокурор, Хууль сахиулах байгууллага, Нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудаас зохиох арга хэмжээ, хамтын ажиллагааг салбар зөвлөлийн ажилтай уялдуулан зохицуулах;
 - 2.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар гадаадын болон дотоодын дэвшилтэт техник, технологи, сайн туршлагыг судалж, түүнийг бусад байгууллага, дүүргийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
 - 2.6. Нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааны зардлыг төсвийн болон холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хуваарилах, зарцуулах;
 - 2.7. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга улирал бүр гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэж, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлнэ.
 - 2.8. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөвлөгөөний дагуу тухайн жилд хийсэн ажлын тайлан болон санхүүгийн тайланг салбар зөвлөлийн хуралдаанд тайлагнана.

Гурав. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн

- 3.1 Салбар зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга батална.
- 3.2 Салбар зөвлөл нь орон тооны нарийн бичгийн даргатай байх бөгөөд орон тооны ажлын албатай байж болно.
- 3.3 Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ажлын албаны дарга байна.
- 3.4 Салбар зөвлөлийн орон тооны нарийн бичгийн дарга бөгөөд дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын албаны даргыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжаар томилно.

Дөрөв. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт

- 4.1. Салбар зөвлөлөөс холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар дүүргийн төсөвт тусгуулан санхүүжүүлнэ.
- 4.2. Салбар зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ.
- 4.3. Салбар зөвлөлийн гишүүдэд ажлын үр дүн, оролцооноос хамааран сар бүр урамшуулал олгоно.
- 4.4. Салбар зөвлөлийн гишүүдийн гарт олгох урамшууллыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй адилтган тогтооно.